



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 0168

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2, 29 дүгээр зүйлийн 29.1.10, 30 дугаар зүйлийн 30.1.12, 30.1.16, 30.2, 30.3, 47 дугаар зүйлийн 47.1.1, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 286 дугаар тушаалаар батлагдсан "Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам"-ын 1.3.2, 1.3.4, 2.1, 2.3, 2.4, 5.1, 9.1, 9.4, "Нийслэлийн Онцгой байдлын газрын дотоод журам"-ын 9.4, 9.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тулгар Төрийн 2228, Их Монгол Улсын 813, Ардын хувьсгалын 98 жилийн ой Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан нийслэлийн Онцгой байдлын газрыг 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 09:00 цагаас 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 09:00 цаг хүртэлх хугацаанд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын хариуцлага, сахилга, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин, нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг харьяа бүтцийн нэгжийн дарга, захирагч нарт даалгасугай.

3. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн өдрүүдэд ерөнхий эргүүл болон жижүүрийн үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хамгаалалтад үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний хуваарийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний хоол, унаа, шатахууны зардалд шаардагдах 1.243.170 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга нэг зуун дал) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж ажилласан тухай дүнг 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 12:00 цагт нэгтгэн танилцуулахыг Дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Мягмардоржид даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА



Ж.ЦУЯТЭМСҮРЭН